



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Аудитын код: УВА-2022/05/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Увс аймгийн Улаангом сум
2022 он

Цахим хуудас: uvs@audit.gov.mn

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317

Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799

Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн “Увс Финанс аудит”
ХХК аудитор: Я.Тунгалаг

Утас: 99459698 Цахим хаяг: anuganzorig85@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	6
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400. Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

**ӨЛГИЙ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА М.ДАВААСҮРЭН
ТАНАА**

Аод.од.д5 № УБА-дод.д/05/11-001-0013
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах зорилготой. Төрийн аудитын үйлчилгээний шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200476

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	496,344.67	454,191.82
33	АВЛАГА	280,844.67	238,691.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	280,844.67	00.00
335	Бусад авлага	00.00	238,691.82
3351	Байгууллагаас авах авлага	00.00	238,691.82
35	БАРАА МАТЕРИАЛ	215,500.00	215,500.00
354	Хангамжийн материал	215,500.00	215,500.00
35410	Бичиг хэргийн материал	24,500.00	24,500.00
35420	Аж ахуйн материал	191,000.00	191,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,265,500.55	4,007,500.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,265,500.55	4,007,500.67
392	Биет хөрөнгө	4,265,500.55	4,007,500.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,377,500.00	14,667,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,376,666.63	-12,292,666.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,027,792.48	10,239,350.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,763,125.30	-8,606,682.74
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,761,845.22	4,461,692.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	464,361.33	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	464,361.33	00.00
413	Өглөг	464,361.33	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	393,361.33	00.00
4136	Бусад өглөг	71,000.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	71,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,297,483.89	4,461,692.49
51	Засгийн газрын хувь оролцоо	4,297,483.89	4,461,692.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,519,520.00	5,519,520.00
51101	Өмч: - төрийн	5,519,520.00	5,519,520.00
512	Хуримтлагдсан үр дүн	-1,343,366.17	-1,110,867.51
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,343,366.17	-1,275,076.11
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	164,208.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	121,330.06	53,040.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,761,845.22	4,461,692.49

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	60,044,400.74	68,232,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,450,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,450,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,450,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,450,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,594,400.74	68,232,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	815,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	815,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,594,400.74	67,417,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,594,400.74	67,417,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	60,448,631.95	68,068,091.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,448,631.95	68,068,091.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,981,557.78	57,553,605.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,062,829.00	41,005,750.58
210101	Үндсэн цалин	31,655,357.00	31,173,285.75
210104	Урамшуулал	10,407,472.00	9,832,464.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,950,692.23	5,381,923.92
210201	Тэтгэврийн даатгал	3,310,869.51	3,699,897.08
210202	Тэтгэмжийн даатгал	391,095.69	420,533.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	312,136.52	336,386.37
210204	Ажилгүйдлийн даатгал	216,035.51	84,009.49
210205	Эрүүл мэндийн даатгал	720,555.00	841,097.60
2104	Хангамж, бараа материалын зардал	3,052,152.00	3,694,000.00
210401	Бичиг хэрэг	525,200.00	957,760.00
210402	Тээвэр, шатахуун	2,493,752.00	2,415,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,200.00	321,000.00
2107	Томилолт, зочны зардал	180,000.00	586,000.00
210702	Дотоод албан томилолт	180,000.00	586,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	186,000.00	227,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	144,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	96,000.00	83,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,549,884.55	6,658,930.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,719,281.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,294,551.00	1,801,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,255,333.55	1,137,999.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	467,074.17	10,514,486.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	9,079,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,313,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	2,766,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	267,074.17	1,434,686.02

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	267,074.17	1,434,686.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-404,231.21	164,208.60
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-404,231.21	164,208.60

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	57,594,400.74	68,232,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,594,400.74	68,232,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	815,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	815,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,594,400.74	67,417,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,594,400.74	67,417,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	57,594,400.74	68,232,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,594,400.74	68,232,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,127,326.57	57,717,813.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,795,687.49	40,958,088.74
210101	Үндсэн цалин	31,866,151.49	31,125,623.91
210104	Урамшуулал	9,929,536.00	9,832,464.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,207,986.08	5,678,125.24
210201	Тэтгэврийн даатгал	3,546,763.36	3,996,098.39
210202	Тэтгэмжийн даатгал	417,795.69	420,533.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	333,436.52	336,386.37
210204	Ажилгүйдлийн даатгал	82,635.51	84,009.50
210205	Эрүүл мэндийн даатгал	827,355.00	841,097.60
2104	Хангамж, бараа материалын зардал	2,758,532.00	3,237,250.00
210401	Бичиг хэрэг	600,000.00	499,960.00
210402	Тээвэр, шатахуун	2,125,332.00	2,416,290.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,200.00	321,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	480,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	480,000.00
2107	Томилолт, зочны зардал	180,000.00	586,000.00
210702	Дотоод албан томилолт	180,000.00	586,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176,400.00	1,420,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,193,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	144,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	86,400.00	83,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,008,721.00	5,357,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,718,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,008,721.00	1,639,000.00

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	467,074.17	10,514,486.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	9,079,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,313,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	2,766,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	267,074.17	1,434,686.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	267,074.17	1,434,686.02
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,519,520.00	121,330.06	2,510,716.89	8,151,566.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,519,520.00	121,330.06	2,510,716.89	8,151,566.95
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,547,877.49	-1,547,877.49
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,519,520.00	121,330.06	-1,343,366.17	4,297,483.89
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,519,520.00	121,330.06	-1,343,366.17	4,297,483.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	68,290.06	68,290.06
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,519,520.00	121,330.06	-1,275,076.11	4,365,773.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-68,290.06	00.00	-68,290.06
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	164,208.60	164,208.60
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,519,520.00	53,040.00	-1,110,867.51	4,461,692.49

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,417,300.00	66,002,613.98	1,414,686.02	98%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,417,300.00	66,002,613.98	1,414,686.02	98%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,337,500.00	56,922,813.98	1,414,686.02	98%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,064,500.00	40,958,088.74	1,106,411.26	97%
210101	Үндсэн цалин	32,022,100.00	31,125,623.91	896,476.09	97%
210104	Урамшуулал	10,042,400.00	9,832,464.83	209,935.17	98%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,678,500.00	5,678,125.24	374.76	100%
210201	Тэтгэврийн даатгал	3,996,100.00	3,996,098.39	1.61	100%
210202	Тэтгэмжийн даатгал	420,600.00	420,533.38	66.62	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	336,500.00	336,386.37	113.63	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	84,100.00	84,009.50	90.50	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	841,200.00	841,097.60	102.40	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	3,238,600.00	3,237,250.00	1,350.00	100%
210401	Бичиг хэрэг	500,000.00	499,960.00	40.00	100%
210402	Тээвэр, шатахуун	2,417,500.00	2,416,290.00	1,210.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	321,100.00	321,000.00	100.00	100%
2107	Томилолт, зочны зардал	594,400.00	586,000.00	8,400.00	99%
210702	Дотоод албан томилолт	594,400.00	586,000.00	8,400.00	99%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,492,500.00	1,420,400.00	72,100.00	95%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,193,400.00	1,193,400.00	0.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	144,000.00	72,000.00	67%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	83,100.00	83,000.00	100.00	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5269000.00	5042950.00	226,050.00	96%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,936,000.00	3,718,950.00	217,050.00	94%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,333,000.00	1,324,000.00	9,000.00	99%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9079800.00	9079800.00	0.00	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,079,800.00	9,079,800.00	0.00	100%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	6,313,200.00	0.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,766,600.00	2,766,600.00	0.00	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	67,417,300.00	67,417,300.00	0.00	100%

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	67,417,300.00	67,417,300.00	0.00	100%
132001	Орон нутгийн төсвөөс	67,417,300.00	67,417,300.00	0.00	100%
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	#DIV/0!
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	6	6	0.00	100%
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	1	1	0.00	100%
620004	Гэрээт ажилтан	4	4	0.00	100%

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	815,000.00	815,000.00	0.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	815,000.00	815,000.00	0.00	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ				
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	815,000.00	815,000.00	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал				
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	815,000.00	815,000.00	0.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	815,000.00	815,000.00	0.00	0.00
31	Нэмэлт санхүүжилтийн орлого				
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815,000.00	815,000.00	0.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого				

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор Я.Тунгалаг гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар хэрэгжүүлсэн

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бие даан зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс эрэдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 60,448.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,208.9 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны нийт зардал 68,068.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,361.4 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг тооцох хувийг 80 хувиар тооцож 1,089.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 257.9 мянган төгрөгөөр буюу 6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс, авлага, өр төлбөр данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	280,844.67	238,691.82	-42,152.85
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	215,500.00	215,500.00	0.0
Үндсэн хөрөнгө	4,265,500.55	4,007,500.67	-257,999.88
Нийт хөрөнгө	4,761,845.22	4,461,692.49	-300,152.73
Өр төлбөр	464,361.33	00.00	-464,361.33
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,297,483.89	4,461,692.49	164,208.60
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,761,845.22	4,461,692.49	-300,152.73

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 42.1 мянган төгрөгийн авлага барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,007.5 мянган төгрөг болж 257.9 мянган төгрөгөөр буурсан нь актлагдсан хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 464.3 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,461.6 мянган төгрөг болж 164.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөн шалтгаалжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгийн данс байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 8,187.8 мянган төгрөгөөр буюу 13.6 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 7,619.4 мянган төгрөгөөр буюу 12.6 хувиар өссөн байна. Энэ нь нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлууд байна. Өмнөх онтой харьцуулахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал шинээр төлөвлөсөн, албан хаагч нэг удаагийн тэтгэмжийн зардал нэмэгдсэн.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 78,417.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 78,417.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 10,185.0 мянган төгрөгөөр бууруулж 68,232.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Цалин болон бичиг хэрэг, тээвэр шатахуун хичээл үйлдвэрлэлийн зардал хасагдсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 68,232.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 68,232.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 67,417.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 66,002.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 66,002.6 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 815.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр өгсөн байна.

Үүнээс хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 815.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгсөн байсан тул Шилэн дансны сайтад байршуулсан мэдээллийг хянаж баталгаажууллаа.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа оруулсан 108, хугацаа хоцроож 9, хугацаа болоогүй 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу батлагдсан төсвийг зарцуулсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг авч ажиллаж 1,434.6 мянган төгрөгийг хэмнэж төвлөрүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах гэсэн зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,719.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 162.2 мянган төгрөгийн алдааг залруулж 1,556.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай 14.2.2 дахь заалтад “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал тусгана” гэж заасны зөрчин 162.2 мянган төгрөгийн татварын авлага дутуу илэрхийлсэн байсныг санхүүгийн тайланд тусгаж залруулга хийлгэсэн.

4.2 Зөвлөмж

1. Зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас замын хуудасгүй, зарцуулалтын тайлангүйгээр 1,556.9 мянган төгрөгийг шатах тослох материалын зардалд зарцуулсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

1. Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас зарцуулсан шатах тослох материалыг замын хуудас, ажлын тайлан бичиж баримтжуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	1,719.1	1	162.2					1	1,556.9


Аудитын явцад бидэнтэй хамтран ажиллаж, зөв бөгөөд ажлаа гүйцэтгэхэд талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.БАТСУУРЫ

М.БАТ-АМГАЛАН

БЭЛТГЭСЭН:

УВС ФИНАНС АУДИТ ХХК-ийн АУДИТОР

/Я.ТУНГАЛАГ/

2022 оны 2-р сарын 18-ны өдөр